



## ХҮҮХДИЙН ЗУРАГ ДҮРСЛЭЛИЙН ДАВТАМЖИД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ (Цэцэрлэгт хамрагдсан 4-5 настай хүүхдийн жишээн дээр)

Ц.Золзаяа<sup>a</sup>  
<sup>a</sup>МУБИС-СӨБС, доктор

Холбоо барих зохиогч: zolzaya.ts@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2025.09.03

Хянагдсан: 2025.10.03

Зөвшөөрсөн: 2025.11.10

### Хураангуй

Сургуулийн өмнөх насны зургийн алтан үе гэж үздэг. Энэ үеийн зураг дүрслэл нь хожим бичиг үсгийн зурлагыг зөв гүйцэтгэх, бичих дасгал болдгоороо чухал ач холбогдолтой. Энэхүү судалгааны зорилго нь сургуулийн өмнөх насны хүүхдийн зураг дүрслэлийн давтагдах байдал учир шалтгааныг тогтоох, эрэгтэй эмэгтэй хүүхдийн дүрслэлийн ялгааг тодорхойлоход чиглэсэн. Судалгааны явцад сургуулийн өмнөх 4 нас 9 сартайгаас 5 нас 11 сар хүртэлх хүүхдийн чөлөөт сэдвээр зурсан зургийн дүр дүрслэлийн давтамжид дүн шинжилгээ хийсэн (N=61). Үүний зэрэгцээ холбогдох онол, үзэл баримтлалыг судлан нөлөөлөх хүчин зүйлийг судаллаа. Түүнчлэн хүүхдийн зураг дүрслэлийн давтамжийг судалснаар зурах үйлийн онцлог, хөгжүүлэх оновчтой арга замыг сонгон хэрэгжүүлэхийн зэрэгцээ энэ талын танин мэдэхүйн хөгжилд чухал үр нөлөө үзүүлэх боломжтой. Үүнээс гадна хүүхэд ертөнцийн зүй тогтлыг танин мэдэх, өөрийгөө илэрхийлэх үйл явцад чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Багш, судлаачдын зүгээс хүүхдийн зурах дуртай сэдэв агуулгыг судалж мэдсэнээр тэдний хэрэгцээ сонирхлыг ойлгох, зургийн сэдвийг оновчтой сонгож зурж дүрслэх ур чадварыг хөгжүүлэх боломж бүрдэнэ.

### Түлхүүр үг

Зураг зурах, сургуулийн өмнөх насны хүүхэд, хэрэгцээ сонирхол, дүрслэлийн ялгаа, хүйсийн ялгаа

### Удиртгал

Судалгааны арга, зорилго, зорилт, хэрэгцээ шаардлага, дэвшүүлж буй асуудал эсвэл судлах асуудлыг авч үзэх болсон шалтгаан, дэвшүүлсэн таамаглал зэргийг дурдана. Times New Roman, 11 pt үсгийн өндөртэйгөөр бичнэ.

## Үндсэн хэсэг гарчиг 1

Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэхэд оршино гэж үзсэн (УИХ, 2023). Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн үе шатыг 2-5 хүртэлх нас гэж тодорхойлсон байдаг. Энэхүү хөгжлийн үе шатны хугацаан дах сургалтын бүх хэлбэр нь тоглоомын шинжтэй байдаг бөгөөд зураг зурах нь хүүхдийн хувьд ур чадвар, оюун ухаан, танин мэдэхүй, сэтгэцийн үйл ажиллагааг хөгжүүлдэг тоглоом, үйлдэл юм. Зурах үйлийн явцад хүүхдийн танин мэдэхүй, мэдрэмж, ойлголт хөгжихийн зэрэгцээ дүр төрх, өнгө, хэлбэр дүрсийг илэрхийлэх ур дүй, авьяас чадвар аажмаар хөгжиж байдаг. Үүний зэрэгцээ зурах үйл нь үг яриагаар илэрхийлэхээс илүүтэй туршлагаа харуулах боломжийг нээж өгч байдаг учир хүүхдүүд зурах дуртай байдаг. Судлаачид хүүхдийн зурах үйлтэй холбоо хамааралтай хэд хэдэн дэвшилтэт онол, үзэл баримтлалыг дэвшүүлсэн байдаг. Тухайлбал, Зигмунд Фрейдийн үндэслэсэн “Психоаналитик” онолыг катарсис онол дээр суурилдаг гэж үздэг бөгөөд энэхүү онол нь хүний зан үйлийн талаарх бие хүний онолуудаас эрс ялгаатай байсан. Түүний энэхүү үзэл санаа нь эрдэм шинжилгээ, судалгааны ажилд өдөр тутамд хэрэглэгддэг шинжлэх ухааны нэр томъёо болж чаджээ. Судлаач Эллис “Катарсис” онолын үндсийг тайлбарлахдаа ямар нэгэн хүчтэй сэтгэл хөдлөл, мэдрэмжээс зайлсхийх үйл явц нь тухайн сэтгэл хөдлөлөө илэрхийлснээр тайлагддаг гэж үзсэн бол Дунсом (1980) “Хүүхдийн зурах үйлийг хүчтэй сэтгэл хөдлөлөө хэсэгчлэн гаргах боломжийг олгодог катарсис үйл явц” гэж тодорхойлсон. Гэсэн хэдий ч Дунсом (1980) катарсис онол нь эмпирик нотолгоо гэхээсээ илүү таамаглал дээр үндэслэсэн гэдгийг анхааруулсан байдаг (Clark,S, 1994, p. 21). Психоаналитик онолд хүүхдийн зурах үйлийг түүний сэтгэл хөдлөл болон гадны хүчин зүйлд хандан хариу үйлдэл үзүүлж буй үйл явц болохыг тэмдэглэсэн байдаг.

Судлаач В.Лоуэнфельд, Б.Эдвардс (1987) нар “Психоаналитик” онолын талаар өөрсдийн үзэл санааг дэвшүүлэхдээ, хүүхэд зургийг тусгалын арга болгон ашигладаг гэсэн ойлголттой холбож үзсэн бөгөөд мэдрэмж, бодол, төсөөлөл бүгд зургаар илэрдэг хэмээн дурджээ (Clark,S, 1994, p. 21). В.Лоуэнфельдийн хүүхдийн зурах үйлийн хөгжлийн үе шат дахь 4-5 нас нь бүдүүвч дүрслэлийн үед хамрах бөгөөд тухайн насны хүүхдийн зурсан зураг нь хүрээлэн буй ертөнц, юмс үзэгдлийн бодит тусгал байдаг. Тухайлбал, хүүхдийн зураг дүрслэл тухайн агшинд тэдний бодол төсөөлөлтэй нийцэж байдаг гол учир байдаг. Сургуулийн өмнөх насны хүүхэд зургийн сэдвээ удаан хайдаггүй. Тэд хамгийн түрүүнд санаанд орсон зүйл болон өөрийн туршлага дээрээ тулгуурлан зурах эсвэл тухайн агшинд харж байгаа бодит зүйлээс санаа авч зурдаг. Хүүхдийн бодол төсөөлөл хөгжихийн хэрээр ой санамжаас сэдэвлэн, зурах чадвар байнга хөгжиж байдаг. Өөрөөр хэлбэл, хүүхэд зурахыг хүссэн зүйлээ дүрслэн бодож өөрийн төсөөллөөр зурдаг онцлогтой (Lowenfeld, V., 1967). Дээрх эрдэмтэн судлаачдын онолын үзэл баримтлалаас үзэхэд хүүхдийн зурах үйл нь тэдний сэтгэл хөдлөл, мэдрэмжээс гадна бодол төсөөллөө илэрхийлэх үйл явц салшгүй холбоотой болох нь харагдлаа.

Орчин цагийн боловсрол судлал, сэтгэл судлалын шинжлэх ухаан нь хүүхдийн зургийн дүн шинжилгээнд үндэслэн, сэтгэл зүйн оношилгооны өргөн цар хүрээтэй

арга хэрэгслийг ашигладаг. Үүнд тодорхой заавар, онооны систем, үр дүнг тайлбарлах арга хэрэгсэл бүхий уламжлалт сонгодог тестүүд ашигладаг. Үүнд: Хүн зурах тест, мод зурах тест гэх мэт (Сергеевна Б. , 2017). Нөгөө талд нь зургийн илэрхийлэл, хувь хүний онцлогийг тодорхойлоход чиглэсэн үзэгдэл судлал, чанарын судалгааны загварт суурилсан аргуудыг хэрэглэдэг. Хүүхдийн зураг дүрслэл нь хүүхдийн хөгжлийн түвшин, хэрэгцээ сонирхол, сэтгэл хөдлөл, төсөөлөл, бүтээлч байдал болон айдас, түгшүүр, сэтгэцийн эмгэгийг бас илэрхийлдэг. Багш, судлаачдын зүгээс дээрх асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хүүхдийн зурсан зургийг судалгааны өгөгдөл болгон ашиглаж тэдний бүтээлд дүн шинжилгээ хийх бүрэн боломжтой.

Судалгааны ажлын хүрээнд 4-5 настай хүүхдийн зураг дүрслэлийн давтамжийн онцлог болон хүйсийн ялгаатай байдалд дүн шинжилгээ хийх, асуудлыг судлах хэрэгцээ шаардлага үүссэн. Энэхүү судалгааны өгөгдөлд чөлөөт сэдвээр зураг зурах хувилбарыг сонгож авсан. “Чөлөөт сэдвээр зурах” гэсэн нэр томъёог урьд өмнө нь ямар нэгэн чиглүүлэг өгөхгүйгээр өөрийн хүсэл сонирхлоор зурах хэв маяг гэж ойлгодог байсан бол. Өнөөдөр ямар нэгэн сэдэвт баригдахгүй хатуу зарчмаар хязгаарлахгүй хүүхдэд зориулсан зурах даалгавар гэж ойлгож болно. Энэ нь судалгааны объектод өөрийн хүссэн сэдвээр зурах боломжийг санал болгодог гэдгээрээ онцлогтой. Харин хүүхдүүд зураг зурахад сөрөг хандлагагүй эсвэл муу туршлагагүй бол ихэвчлэн зөвшөөрдөг. Үүний үр дүнд хүүхэд сайн мэддэг сэдвээ сонгох боломжтой бөгөөд энэ нь тэдний хувьд зурахад хялбар байдаг. Түүнчлэн шинэ сэдэв сонгох боломжтой бөгөөд сонирхолтой хэдий ч энэ нь оюун ухаан, ур дүй, цаг хугацааг ихээхэн шаарддаг. Хүүхдийн зурсан зурагт хүрээлэн буй орчноос шалтгаалсан дүрслэлийн ялгаа ихээр илрэх бөгөөд ихэвчлэн “хүн, амьтан, гэр, байшин, мод, цэцэг навч, тээврийн хэрэгсэл”-ийн зураг дүрслэл цөөнгүй тохиолддог. Судлаачийн зүгээс хүүхдийн зураг бүтээлийн сэдэв агуулгаас түүвэрлэн авсан гэр, байшин, цэцэг, машин, онгоц, хүн, амьтан, эд юмс, нар, сар, од, тоглоом, гар утас, хүүхэлдэйн киноны баатар, үлгэрийн баатар гэсэн 14 зураг дүрслэлийг сонгож авсан. 4-5 настай хүүхдийн зураг дүрслэлийн давтагдах шинж чанар, шинэ дүр дүрслэлийг бүтээх болон хүйсийн ялгаатай байдлыг илэрхийлсэн эсэхийг судалгааны үр дүнгээс харцгаана уу.

**Судалгааны зорилго:** 4-5 настай эрэгтэй, эмэгтэй хүүхдийн зураг дүрслэлийн давтамжийг харьцуулан шинжилж, хүйсийн ялгааг тодорхойлох

### Судалгааны асуулт:

1. Хүүхдийн зурсан зургийн агуулгад ямар дүр дүрслэлүүд багтдаг вэ?
2. Хүүхдийн зураг, дүрслэл хэрхэн давтагддаг вэ? Онцлог нь юу вэ?
3. Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн зурсан зургийн дүр дүрслэл хоорондоо ямар ялгаатай вэ?

## Судалгааны арга зүй

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд нийслэлийн СХД-ийн 104-р цэцэрлэгийн бэлтгэл А бүлгийн 30 хүүхэд, Б бүлгийн 31 хүүхдээс эрэгтэй 34, эмэгтэй 27 нийт 61 хүүхэд хамрагдсан. Судалгааны явцад хүүхдийн зурах үйлийн ажиглалт, тэмдэглэл хөтөлж, бүтээлд дүн шинжилгээ хийх аргаар мэдээлэл цуглуулж, судалгааны өгөгдлөө SPSS 26.0 программ ашиглан, математик боловсруулалт хийж, дүгнэлт гаргасан.

Хүүхдийн зураг дүрслэлийн давтамжийн онцлог, хүйсийн ялгаатай байдлыг илрүүлэх аргачлалыг боловсруулахдаа судлаач В.Ловенфилд, Б.Эдварс (АНУ) нарын тодорхойлсон хүүхдийн зурах үйлийн хөгжлийн үе шатууд дахь 5-7 хүртэлх нас буюу “Бүдүүвч дүрслэлийн үе”-ийг баримжаалсан. Судалгааны шалгуур үзүүлэлтийн агуулгын шинжилгээг хийхдээ салбарын мэргэжлийн эрдэмтдэд (экспертүүд) танилцуулж санал, зөвлөгөөг тусгаж сайжруулж ажилласан. Энэхүү аргачлал нь 4 шалгуур үзүүлэлт, үнэлгээний хэрэгсэлтэй бөгөөд хүүхдийн зурсан зургийн сэдэв агуулгын давтамжийн үзүүлэлтийг давтамжийн тоогоор эрэмбэлж оноолуулсан. Түүнчлэн зургийн сэдэв агуулгын давтамжийн үзүүлэлтийг хүүхэд тус бүрээр болон хүйсээр нь ангилсан.

**Судалгааны аргачлал:** Бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд зурах хэрэгслүүдийг тараан өгч чөлөөт сэдвээр зуруулна. Багш ажиглалтын тэмдэглэл хөтөлж фото зургаар баримтжуулсан.

**Судалгааны түүвэр:** Түүвэрт сургуулийн өмнөх 4 нас 9 сартайгаас 5 нас 11 сар хүртэлх хүүхдүүд хамрагдсан. Түүврийн тоо  $n=61$ . Түүвэрт хамрагдсан хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчаас бичгээр зөвшөөрөл авсан.

Хүүхдийн зураг дүрслэлийн давтамжийн шинжилгээнд гурван үе шатаас бүрдсэн боловсруулалт хийсэн. Үүнд:

1. Зургуудыг кодолж сканердах
2. Кодолсон зургуудыг сэдэв, зураг дүрслэлээр нь ангилах
3. Ангилсан зургуудыг 14 төрөл зүйлээр нь нэгтгэх

Зураг дүрслэлийг ангилж нэгтгэсэн байдал

- Тээврийн хэрэгсэл - Суудлын машин, жийп, автобус, танк, скутер, онгоц
- Хүн - Гэр бүл, өөрийн хөрөг, гүнж, анимийн дүр
- Тэмдэгтүүд - Зүрх, смайл
- Байшин - Зуслангийн байшин, хаус, цэцэрлэг
- Нар - Нар
- Байгал - Чулуу, солонго, толгод, нуур
- Тоглоом - Бөмбөлөг, хүүхэлдэй
- Амьтан - Нохой, морь, туулай
- Үүл - үүл, уул
- Цэцэг, өвс - Баглаа цэцэг, нугын цэцэг, ногоон өвс
- Зам - Засмал зам, шороон зам
- Мод - Гацуур, бусад
- Шувууд - Шувуу
- Шавж - Эрвээхэй

Дээрх зураг дүрслэлийг ангилж нэгтгэсэн судалгааны өгөгдлүүдийг SPSS 26.0 программ ашиглан, математик боловсруулалт хийж үр дүнг тооцов.

## Судалгааны үр дүн

4-5 настай хүүхдийн зураг дүрслэлийн давтамжийн үзүүлэлт:

Хүснэгт 1. Хүүхдийн зураг дүрслэлийн давтамжийн шинжилгээ (n=61)

Sex	n	Sum	Min	Max	Mean	SD	Mode	Median
Эрэгтэй	34	66(41.5%)	1	8	1.94	1.79	1	1
Эмэгтэй	27	93(58.5%)	1	23	3.44	4.85	1	1
Нийт	61	159(100%)	1	23	2.61	3.54	1	1

Судалгаанд хамрагдсан эрэгтэй, эмэгтэй хүүхэд бүрийн бүтээлд нийт 159 зураг дүрслэл давтагдсан болохыг дээрх судалгааны үр дүнгээс харж болно. Харин тархалтын үзүүлэлтүүдийг авч үзвэл хамгийн бага ба хамгийн их утга болон стандарт хазайлт нь эмэгтэй, эрэгтэй хүүхдийн хооронд мэдэгдэхүйц ялгаа байгааг харуулж байна. Төвийн хандлагын үзүүлэлтүүдийг авч үзвэл дундаж утга, хоёр бүлгийн төвийн хандлагын үзүүлэлт бараг ижил буюу маш төстэй байгааг харуулж байна. Охид, хөвгүүдийн ихэнх нь нэг объект зурсан бол дундаж утга нь мөн 1 байна. Дундаж утга нь бүлгүүдийн хоорондын ялгааг харуулж байна.

Хүснэгт 2. Объектын давтамжийн шинжилгээ (n=61, No=107)

THEME	Frequency	Percent of all objects drawn (n / 107)	Percent of children who used it (n / 61)
тээврийн хэрэгсэл	18	16.82	29.50
хүн	15	14.02	24.60
тэмдэгт	13	12.15	21.30
байшин	12	11.21	19.70
нар	10	9.35	16.40
мод	6	5.61	9.80
тоглоом	5	4.67	8.20
амьтан	5	4.67	8.20
үүл	5	4.67	8.20
цэцэг	5	4.67	8.20
өвс навч	5	4.67	8.20
шавж	4	3.74	6.60
шувуу	3	2.80	4.90
зам	1	0.93	1.60
Нийт	107	100.00	--

Зураг дүрслэлийн давтамжийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд нийт хүүхдийн 21.3%-29.5% нь нэгээс олон тээврийн хэрэгсэл, хүн, тэмдэгт, байшин, мод, цэцэг навч, эд юмсыг зурсан тул объектын давтамжийн нийлбэр 107 хүртэлх үр дүнг

үзүүлсэн. Эдгээрээс “Тээврийн хэрэгсэл, хүн, тэмдэгт” -ийн зураг дүрслэл хамгийн олон давтагдсан бөгөөд нийт дүрслэлийн 43% -ийг эзэлж байна.

Хүснэгт 3. Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн зураг дүрслэлийн давтамжид хийсэн дүн шинжилгээ  
(nb =34, ng =27)

THEME	Percentage of Boys	Percentage of Girls	$\chi^2$	p	Eta (sex dep.)
тээврийн хэрэгсэл	52.9	0.0	20.278	.001	0.577
нар	2.9	33.3	10.142	.001	0.408
үүл	0.0	18.5	6.086	.009	0.335
цэцэг	0.0	18.5	6.858	.009	0.335
мод	2.9	18.5	4.118	.042	0.260
шувуу	0.0	11.1	3.973	.046	0.255
амьтан	2.9	14.8	2.820	.093	0.215
шавж	2.9	11.1	1.639	.200	0.164
зам	0.0	3.7	1.280	.258	0.145
хүн	29.4	18.5	0.963	.326	0.126
тэмдэгт	17.7	25.9	0.615	.433	0.100
байшин	20.6	18.5	0.041	.840	0.026
өвс навч	5.9	7.4	0.400	.841	0.026
тоглоом	5.9	7.4	0.400	.841	0.026

Судалгааны үр дүнгээс үзэхэд эрэгтэй 34 хүүхдийн зураг дүрслэлийн давтамжийн тархалт нь 0,24%-ийг үзүүлсэн бөгөөд, тээврийн хэрэгсэл, хүн, тэмдэгт, байшингийн зураг дүрслэл илүүтэй зонхилсон байна. Эмэгтэй 27 хүүхдийн зураг дүрслэлийн давтамжийн тархалт нь 0,13%-ийг үзүүлсэн. Эмэгтэй хүүхдийн хувьд нар, үүл, мод, цэцэг, тэмдэгт, шувуу гэсэн зургаан сэдвийн хүрээнд хамгийн их давтамжийн тархалт харагдаж байна. Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн чөлөөт сэдвээр зурсан зургууд нь илүү өргөн хүрээг хамарсан бөгөөд эмэгтэй хүүхдийн хувьд 14 зураг дүрслэлээс 13-ыг зурсан бол эрэгтэй хүүхэд зөвхөн 10 зураг дүрслэлийг гүйцэтгэсэн болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Судалгааны эцсийн үр дүн нь хүүхдийн зураг дүрслэлийн давтамжийн онцлог, хүйсийн ялгаатай байдал зураг бүтээлд хэрхэн илэрч байгаад дүн шинжилгээ хийж үр дүнг тооцох явдал байлаа. Судалгаанд нийт 61 хүүхэд хамрагдсан бөгөөд үүнээс эрэгтэй 34, эмэгтэй 27 хүүхэд байв. Насны хувьд 4 нас 9 сартайгаас 5 нас 11 сар хүртэлх хүүхдүүд түүвэрт хамрагдсан. Хүүхдийн зураг дүрслэлийн давтамжийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд давтамжийн нийлбэр 107 хүртэлх үр дүнг үзүүлсэн. Хэдийгээр зураг дүрслэлийн давтамжийн нийлбэр 107 байгаа боловч ихэнх хүүхдүүд зөвхөн нэг төрлийн зураг зурсан байгаа нь судалгааны үр дүнгээс харагдсан. Цаашид хүүхдийн зурах үйлийн хөгжлийн ерөнхий хандлагаас үзэхэд нас нэмэх тусам зурах дүр дүрслэлийн тоо нэмэгддэг болох нь зураг, урлалын сургалт үйл ажиллагааны явцад ажиглагддаг. Жишээлбэл: 4 настай хүүхдийн

зурсан зургийн 13% -д нэг салангид дүрслэл илэрдэг бол 5 настай хүүхдүүдийн 6%, 6 настай хүүхдийн 1% -д илэрдэг. Зарим сэдэв агуулга дээрх зураг дүрслэлийн эзлэх хувь бага байгаа нь хүүхдүүд оюун ухаан, ур чадварт биш технологид илүү их найддаг болсон нь мэдээллийн дижитал эриний нөлөө байж болох юм. Бидний судалгааны үр дүнгээс үзэхэд эмэгтэй хүүхдийн зураг дүрслэлийн дундаж тоо илүү өндөр буюу 4-5 төрөл байсан бол эрэгтэй хүүхэд ердөө 2-3 төрлийн дүр дүрслэлийг гүйцэтгэсэн байна. Энэхүү ялгаа нь хүйсийн ялгааг илэрхийлж болно. Эмэгтэй хүүхдийн зурах үйл, хөдөлгөөний ур чадвар эрэгтэй хүүхдээс илүү хурдтай хөгжиж байдаг. Эмэгтэй хүүхдийн хувьд ихэвчлэн 4 настай, хөвгүүдийн хувьд 4.6-5 наснаас эхлэн сэдэвт зураг зурж эхэлдэг ба зарим үед эмэгтэй хүүхэд зурах үйлийн хөгжлөөр эрэгтэй хүүхдээс 4-6 сараар түрүүлэх тохиолдол байдаг. Үүнийг эрэгтэй хүүхдийн хувьд хөгжлөөр хоцорч байна гэж үзэхгүй. Эмэгтэй хүүхдийн хувьд хүн, нар, мод, цэцэг зурахдаа илүү их сэтгэл ханамжийг мэдэрдэг бол эрэгтэй хүүхэд тээврийн хэрэгсэл, байшин, хүн зурахыг илүүд үздэг болох нь судалгааны явцад ажиглагдсан. Энэхүү хүйсийн ялгаа нь цаашид аажмаар буурах хандлагатай болохыг тэмдэглэх нь зүйтэй.

## Дүгнэлт

Энэхүү судалгаа нь 4-5 настай хүүхдийн зураг дүрслэлийн давтагдах шинж чанаруудыг харьцуулах, хүйсийн ялгаатай байдалд дүн шинжилгээ хийх явдал байв. Хүүхдийн зураг бүтээл дэх давтамжийн шинж чанаруудыг харьцуулж, шинжлэн судалснаар 4-5 настай хүүхдийн зургийн онцлог, нийтлэг байдлыг илүү сайн ойлгож, хүүхдийн зурах чадвар, танин мэдэхүйн хөгжилд илүү шинжлэх ухаанч чиг хандлагыг өгөх болно. Энэхүү судалгааны хүрээнд 4-5 настай эрэгтэй, эмэгтэй 61 хүүхдийн зураг бүтээлд ажиглалт, дүн шинжилгээ хийсний үр дүнд зургийн ерөнхий шинж чанар, зурсан зургийн сэдэв, зураг дүрслэлийн давтамж, хүйсийн ялгаатай байдлыг нэгтгэн дүгнэж математик боловсруулалт хийв (Хүснэгт1). Хүүхдийн зураг дүрслэлийн давтамжийн шинжилгээнээс үзэхэд нийт эрэгтэй, эмэгтэй 61 хүүхдийн бүтээлд 159 зураг дүрслэл давтагдсан үр дүн гарсан. Хүйсийн ялгаатай байдлыг шинжилж үзэхэд эрэгтэй хүүхдийн зураг дүрслэлийн давтамжид тээврийн хэрэгсэл ( $V=0.58$ ,  $p<.001$ ); хүн ( $V=0.12$ ,  $p<.326$ ); ач холбогдолтой буюу хамгийн их утга үзүүлсэн. Түүнчлэн эмэгтэй хүүхдийн зураг дүрслэлийн давтамжаас үзэхэд нар ( $V=0.48$ ,  $p<.001$ ); үүл ( $V=0.34$ ,  $p<.009$ ); цэцэг ( $V=0.34$ ,  $p<.009$ ); ач холбогдолтой буюу хамгийн их утга үзүүлсэн. Харин тархалтын үзүүлэлтүүдийг харьцуулж үзэхэд хамгийн бага ба хамгийн их утга болон стандарт хазайлт нь эмэгтэй, эрэгтэй хүүхдийн хооронд мэдэгдэхүйц ялгаа байгааг харуулж байна.

## Талархал

“Хүүхдийн зураг дүрслэлийн давтамжид хийсэн дүн шинжилгээ” сэдэвт судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн Сонгинохайрхан дүүргийн 104-р цэцэрлэгийн бэлтгэл А, Б бүлгийн хүүхдүүд болон багш, удирдлагуудад талархал илэрхийлье.

## Ном зүй

1. Боловсрол шинжлэх ухаан, спортын яам. (2019). Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөмж. Улаанбаатар: Соёмбо принтинг.
2. Улсын их хурал. (2023). Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль. Улаанбаатар
3. Григорьева, Г.Г. (2006). Теория и методика развития детского изобразительного творчества. Москва: Владос
4. Казакова, Р.Г. (2006). Теория и методика развития детского изобразительного творчества. Москва: Владос
5. Лыкова, И.А. (2013). Изобразительная деятельность в детском саду. Старшая группа. Москва: Цветной мир
6. Лыкова, И.А. (2013). Изобразительная деятельность в детском саду. Подготовительная группа к школе. Москва: Цветной мир
7. Сергеевна, Б.Л. (2017). Развитие эмоциональной отзывчивости у детей старшего дошкольного возраста в изобразительной деятельности. Выпускная квалификационная работа. Екатеринбург:
8. Clark, S. (1994). A study of children's drawing types and factors influencing choice of subject matter. Edith Cowan University
9. Lowenfeld, V. (1967). Creative and Mental Growth. (7th ed.). New York: Macmillan.

## **ANALYSIS OF THE FREQUENCY OF CHILDREN'S DRAWINGS AND REPRESENTATIONS**

**(Based on the example of 4–5-year-old children attending kindergarten)**

<sup>a</sup>Zolzaya Ts.

<sup>a</sup>PhD., School of Pre-School Education, MNUE

Corresponding author: zolzaya.ts@msue.edu.mn 

### **Abstract**

Preschool age is considered the golden period of drawing. At this stage, children's drawings and representations are of great importance, as they later serve as preparation for correct handwriting and writing practice. The purpose of this study is to identify the causes of repetition in preschool children's drawings and representations, and to determine the differences between boys' and girls' representations. During the study, the drawings created by children aged 4 years 9 months to 5 years 11 months on free topics were analyzed for the frequency of recurring images (N=61). In addition, relevant theories and concepts were reviewed, and influencing factors were studied. By examining the frequency of children's drawings, it becomes possible to identify the characteristics of the drawing activity and to select and apply optimal methods for development, while also making a significant contribution to cognitive development in this area. Furthermore, children's drawings are considered important in helping them understand the laws of the world and express themselves. By studying the subjects and content that children enjoy drawing, teachers and researchers can better understand their needs and interests, select appropriate drawing topics, and foster their representational and drawing skills.

### **Keywords**

Drawing, preschool children, needs and interests, representational differences, gender

---